



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/155/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг:
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	
2.11	Шилэн дансны мэдээлэл	
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	
3	Менежментийн захидал	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА
2020.02.28 № 1-6/151	
танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.АРИУНАА



Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга Д.Цэндмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 сарын 05-ны өдрөөс 2020 оны 02 сарын 08-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын эрхэм зорилго нь Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын үйл ажиллагаа
- Улирлын шинжтэй Ахмадын сувилал

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 960,568.2 мянган төгрөгөөс тооцон 19,211.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,104.5 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,891.9	31,204.7	28,312.8
Бараа материал	71,272.5	68,053.0	-3,219.5
Үндсэн хөрөнгө	1,219,211.8	1,225,658.8	21,405.1
Нийт хөрөнгө	1,033,065.2	937,908.8	--95,104.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,033,065.2	937,908.8	--95,104.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,033,065.2	937,908.8	--95,104.5

Авлага дансны үлдэгдэл өссөн нь ажиллагсдаас авах авлага 16,780.8 мянган төгрөгөөр, бусад зардлын авлага 10,532.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. 2019 онд шинээр үүсэн ажиллагсдаас авах авлага НДШ-ийн илүү төлөлт, байгууллагаас авах авлага нь төвлөрүүлсэн орлогын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь эм боох материалын үлдэгдэл 67.2 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материалын үлдэгдэл 760.8 мянган төгрөгөөр, хүнсний материал 1,955.5 мянган төгрөгөөр тус тус өсч, аж ахуйн материалын үлдэгдэл 3,535.0 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 800.0 мянган төгрөгөөр, түлш шатах материалын үлдэгдэл 1,668.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Ашиглалтын хугацаа дууссан Асрамжийн газрын зөөлөн эдлэл, сэлбэг, хэрэгслийг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тоног төхөөрөмж 6,447.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ 6,447.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ус цэвэршүүлэгчийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 937,950.7 мянган төгрөг болж 95,104.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар тайлант онд 23,265.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 23,265.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	23,265.0	23,265.0		100
Нийт дүн	23,265.0	23,265.0		100

Тус газрын ахмадын сувиллын үйл ажиллагаанаас шалтгаалж орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 799,135.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 799,135.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 775,870.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 23,265.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлыг нийт 10,562.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалин хөлсний зардлыг 8,631.5 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 245.5 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 977.4 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 471.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 222.3 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 44,223.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, тус газрын дэргэдэх Ахмадын асрамжийн төвийн үйл ажиллагаанд зарцуулсан байна Нэмэлт санхүүжилтийн тайланг программаас татаж гаргаагүй байна

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 24,233.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 14,958.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,174.5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1,100.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 24,233.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8,174.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тайлант оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлтээс 8,105.1 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтууд, УСНББОУС 18-ын 19 /а/ заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Албан томилолтоор ажиллагсдад анхан шатны баримтгүй буюу томилолтын хоног илүү тооцож 69,4 мянган төгрөгийн томилолтын нөхөн олговор олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, УСНББОУ 18 стандарттай нийцээгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 1,100.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 547.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 77,915.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг

үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Шатахууны зарцуулалтыг нормоор тооцон хянахад замын хуудсаар километрийн бичилт дутуу бичигдсэнээс 1,100.9 мянган төгрөгийн шатахуун нормативаас илүү зарцуулсан мэт харагдаж байна.

Менежментийн захидал

3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Шатахууны зарцуулалтыг хянахад замын хуудсанд 1,100.9 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын километрийн бичилт дутуу байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тээвэр шатахууны зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудасны бичилтийг сайжруулах, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>74,164,393.60</u>	<u>99,257,777.21</u>
33	АВЛАГА	2,891,904.00	31,204,756.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,531,904.00	19,312,756.00
335	Бусад авлага	360,000.00	11,892,000.00
3351	Байгууллагаас авах авлага	360,000.00	11,892,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,272,489.60	68,053,021.21
351	Түүхий эд материал	187,760.00	255,025.00
35130	Эм боох материал	187,760.00	255,025.00
354	Хангамжийн материал	71,084,729.60	67,797,996.21
35410	Бичиг хэргийн материал	2,885,440.00	3,646,175.00
35420	Аж ахуйн материал	62,220,243.00	58,685,201.00
35430	Сэлбэг хэрэгсэл	861,100.00	61,100.00
35440	Түлш, шатах тослох материал	3,722,686.40	2,054,740.01
35460	Хүнсний материал	1,395,260.20	3,350,780.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>958,900,805.07</u>	<u>838,692,925.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	958,900,805.07	838,692,925.06
392	Биет хөрөнгө	391,540,205.11	305,695,325.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	20,914,713.75	20,914,713.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-305,412.30	-20,890,985.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,448,000.00	50,448,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,715,873.40	-29,093,873.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	338,222,926.86	344,669,916.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,331,930.87	-207,451,618.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231,461,582.95	231,461,582.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,853,801.88	-85,495,744.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,766,594.00	10,766,594.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,066,594.00	-9,633,260.64
393	Биет бус хөрөнгө	567,360,599.96	532,997,599.88
39303	Бусад биет бус хөрөнгө	567,398,000.00	567,398,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-37,400.04	-34,400,400.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,033,065,198.67</u>	<u>937,950,702.27</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,033,065,198.67</u>	<u>937,950,702.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,033,065,198.67	937,950,702.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	756,435,814.51	756,435,814.51
51101	Өмч: - төрийн	756,435,814.51	756,435,814.51
512	Хуримтлагдсан үр дүн	255,962,548.16	160,848,051.76
51210	Өмнөх үеийн үр дүн	255,962,548.16	255,962,548.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-95,114,496.40
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,666,836.00	20,666,836.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,033,065,198.67</u>	<u>937,950,702.27</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	381,023,368.00	880,411,845.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,811,461.00	50,747,905.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,811,461.00	50,747,905.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,811,461.00	50,747,905.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,520,000.00	23,265,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,291,461.00	27,482,905.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	351,211,907.00	829,663,940.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	341,849,900.00	775,870,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	341,849,900.00	775,870,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,045,000.00	53,793,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,925,000.00	42,261,340.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,000.00	00.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	11,532,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,317,007.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,317,007.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	346,312,645.79	975,526,341.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,312,645.79	975,526,341.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,220,838.79	943,652,573.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,825,148.00	492,128,949.00
210101	Үндсэн цалин	196,805,148.00	477,705,699.00
210102	Нэмэгдэл	00.00	456,750.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,020,000.00	13,966,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,148,000.00	65,001,660.00
210201	Тэтгэврийн даатгал	26,148,000.00	65,001,660.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,748,080.45	78,107,194.99
210301	Гэрэл, цахилгаан	2,542,022.00	6,304,477.00
210302	Түлш, халаалт	29,228,526.45	65,314,121.99
210303	Цэвэр, бохир ус	2,977,532.00	6,488,596.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,906,946.00	74,798,300.91
210401	Бичиг хэрэг	3,915,880.00	9,752,165.00
210402	Тээвэр, шатахуун	6,565,870.00	14,291,675.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,825,986.00	3,461,168.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,599,210.00	47,293,292.00
2105	Нормативт зардал	13,739,068.80	37,709,680.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,155.00	889,150.00
210502	Хоол, хүнс	13,461,913.80	36,820,530.00

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,758,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,604,750.00
210604	Урсгал засвар	00.00	1,153,500.00
2107	Томилолт, зочны зардал	233,800.00	9,430,200.00
210702	Дотоод албан томилолт	233,800.00	9,430,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,048,177.00	50,687,869.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,349,527.00	47,638,269.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,079,000.00	2,016,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	587,550.00	594,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,100.00	32,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	407,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,571,618.54	130,030,470.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,127,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	248,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,571,618.54	126,654,870.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,091,807.00	31,873,767.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,091,807.00	2,740,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,317,007.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,774,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,740,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	27,933,767.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,933,767.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,200,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>34,710,722.21</u>	<u>-95,114,496.40</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,710,722.21</u>	<u>-95,114,496.40</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>722362733.00</u>	<u>841396940.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>32754000.00</u>	<u>11733000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	32754000.00	11733000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32754000.00	11733000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32754000.00	11733000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>689608733.00</u>	<u>829663940.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	646411600.00	775870600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	646411600.00	775870600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35370256.00	53793340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35235256.00	42261340.00

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135000.00	
131106	Төсвийн урамшуулал		11532000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7826877.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7826877.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	714377964.00	836889940.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714377964.00	836889940.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655660183.77	805016172.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433437029.00	511381705.00
210101	Үндсэн цалин	379666897.00	496958455.00
210102	Нэмэгдэл	42230632.00	456750.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11539500.00	13966500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54064661.00	65001660.00
210201	Тэтгэврийн даатгал	54064661.00	65001660.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67431102.76	80251919.00
210301	Гэрэл, цахилгаан	4960151.00	6304477.00
210302	Түлш, халаалт	54698831.76	67458846.00
210303	Цэвэр, бохир ус	7772120.00	6488596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25057964.01	25348343.51
210401	Бичиг хэрэг	6912358.00	5780200.00
210402	Тээвэр, шатахуун	7565495.00	9314640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3586237.01	3475168.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6993874.00	6778335.00
2105	Нормативт зардал	32960632.00	51423225.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	335020.00	712915.00
210502	Хоол, хүнс	31170112.00	39604610.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1455500.00	11105700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4096915.00	5120635.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1059990.00	18900.00
210602	Тавилга	150000.00	
210604	Урсгал засвар	2886925.00	5101735.00
2107	Томилот, зочны зардал	906400.00	9430200.00
210702	Дотоод албан томилот	906400.00	9430200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37344480.00	52198585.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33883130.00	48838985.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2079000.00	2016000.00
210803	Даатгалын үйлчилгээ	587550.00	594000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50300.00	32100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722700.00	717500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	361000.00	4859900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	361000.00	3575900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1284000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58717780.23	31873767.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	27601677.00	2740000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7826877.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19774800.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2740000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31116103.23	27933767.49

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31116103.23	27933767.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1200000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		1200000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7984769.00</u>	<u>4507000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7984769.00	4507000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7984769.00	4507000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7984769.00	4507000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7984769.00	4507000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7984769.00</u>	<u>-4507000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,411,814.51	19,771,016.00	280,904,705.36	490,087,535.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,969,159.00	3,969,159.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,411,814.51	19,771,016.00	284,873,864.36	494,056,694.87
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	19,771,016.00	63,212,718.91	82,983,734.91
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,435,814.51	20,666,836.00	255,962,548.16	1,033,065,198.67
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,435,814.51	20,666,836.00	255,962,548.16	1,033,065,198.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	756,435,814.51	20,666,836.00	255,962,548.16	1,033,065,198.67
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-95,114,496.40	-95,114,496.40
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,435,814.51	20,666,836.00	160,848,051.76	937,950,702.27

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	669676600.00	662242856.77	799550100.00	812308172.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	669676600.00	662242856.77	799550100.00	812308172.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649901800.00	642468056.77	796800100.00	809568172.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437538100.00	433437029.00	520013200.00	511381705.00
210101	Үндсэн цалин	352168800.00	379666897.00	411222200.00	496958455.00
210102	Нэмэгдэл	64276400.00	42230632.00	87698100.00	456750.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21092900.00	11539500.00	21092900.00	13966500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54064700.00	54064661.00	65001700.00	65001660.00
210201	Тэтгэврийн даатгал	36043200.00	54064661.00	45935400.00	65001660.00
210202	Тэтгэмжийн даатгал	4505300.00		4766300.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	3604400.00		3813700.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	901000.00		952600.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	9010800.00		9533700.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67436100.00	67431102.76	80497400.00	80251919.00
210301	Гэрэл, цахилгаан	14252600.00	4960151.00	9252700.00	6304477.00
210302	Түлш, халаалт	45573000.00	54698831.76	63634200.00	67458846.00
210303	Цэвэр, бохир ус	7610500.00	7772120.00	7610500.00	6488596.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17920600.00	17725798.01	16420600.00	25348343.51
210401	Бичиг хэрэг	3544700.00	3698858.00	3544700.00	5780200.00
210402	Тээвэр, шатахуун	4773400.00	4903800.00	4773400.00	9314640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3461100.00	2356237.01	3461100.00	3475168.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6141400.00	6766903.00	4641400.00	6778335.00
2105	Нормативт зардал	34688600.00	32960632.00	52232600.00	51423225.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643500.00	335020.00	643500.00	712915.00
210502	Хоол, хүнс	30402200.00	31170112.00	41902200.00	39604610.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3642900.00	1455500.00	9686900.00	11105700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9271700.00	8726684.00	9271700.00	9259985.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3724700.00	5839759.00	3724700.00	4158250.00
210602	Тавилга				
210604	Урсгал засвар	5547000.00	2886925.00	5547000.00	5101735.00
2107	Томилолт, зочны зардал	1247000.00	868200.00	1247000.00	9475200.00
210702	Дотоод албан томилолт	1247000.00	868200.00	1247000.00	9475200.00

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27240000.00	26892950.00	51620900.00	52198585.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23693800.00	23431600.00	48063500.00	48838985.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2079000.00	2079000.00	2079000.00	2016000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594000.00	587550.00	594000.00	594000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128700.00	50300.00	128700.00	32100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21800.00	21800.00	33000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722700.00	722700.00	722700.00	717500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495000.00	361000.00	495000.00	5227550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	495000.00	361000.00	495000.00	3943550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				1284000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19774800.00	19774800.00	2750000.00	2740000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19774800.00	19774800.00	2750000.00	2740000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19774800.0	19774800.0		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			2750000.00	2740000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	669676600.00	679165600.00	799135600.00	832796432.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	646411600.00	646411600.00	775870600.00	765307932.51
131001	Улсын төсвөөс санхүүжих	646411600.0	646411600.0	775870600.00	765307932.51
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23265000.00	32754000.00	23265000.00	67488500.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23265000.0	32754000.0	23265000.00	23265000.00
120004 4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				44223500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1020.00	58301.00	1020.00	58301.00
620001	Удирдах ажилтан	555.0	7878.0	555.00	7878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.0	4545.0	455.00	4545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.0	45878.0	10.00	45878.00

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			414500.00	23735240
21	УРСГАЛ ЗАРДАЛ			414500.00	23735240

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			414500.00	23735240
2104	Хангамж, бараа материалын зардал				8919340
210401	Бичиг хэрэг				1682000
210402	Тээвэр, шатахуун				6624840
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр				580000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс				32500
2105	Нормативт зардал				168000
210502	Хоол, хүнс				168000
2107	Томилолт, зочны зардал				8699500
210702	Дотоод албан томилолт				8699500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			414500.00	1214500
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			414500.00	1214500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				4733900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				3449900
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				1284000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				44223500
1310	Нэмэлт санхүүжилт				44223500
131001	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвийн доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				44223500